



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Г Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.8.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагатай байгуулах “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан гэрээний үлгэрчилсэн загварын дагуу эрүүл мэндийн байгууллагуудтай “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ” болон “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ”-г шинэчлэн байгуулах үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны “Эрүүл мэндийн даатгалын гэрээний үлгэрчилсэн загварыг батлах тухай” 12 дугаар тогтоол, 2020 оны “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай” 12 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Л.Номин/-нд даалгасугай.

ДАРГА

С.ЭНХБОЛД



Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн  
2021... оны 12 дугаар сарын 21.. -ний өдрийн  
13.. дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

1117149845  
ТУЗ0845 Я 5284708

БАТЛАВ.  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭГ ХУДАЛДАН АВАГЧ:

БАТЛАВ.  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ:

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

ЭМДЕГ-ЫН ДАРГА

ЭМБ-ЫН ДАРГА, ЗАХИРАЛ

### ДААТГУУЛАГЧДАД ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

202... оны.. дугаар  
сарын ..-ны өдөр

Дугаар .....

.....хот/аймаг

Нэг талаас регистрийн дугаартай ..... ХХК/ байгууллагын ..... аймаг/нийслэлийн ..... сум/дүүрэгт байрших ..... эмийн сан (цаашид “эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгч” гэх) нөгөө талаас Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (цаашид “Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг худалдан авагч”, хамтад нь “талууд” гэх) нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг ..... оны ..... сарын .....-ны өдрөөс ..... оны ..... сарын ..... өдөр хүртэл ..... хугацаанд мөрдөхөөр байгуулав.

#### НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг худалдан авагч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, тусгай зөвшөөрөлтэй эмийн сангаас хүсэлтийг нь хүлээн авч, шалгуурт тэнцсэн тохиолдолд “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ”-г байгуулна.

1.2. Энэхүү гэрээгээр эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгч нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн (цаашид “ЭМДҮЗ” гэх) тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хувь, хэмжээ” бүхий жагсаалт (цаашид “Хөнгөлөлттэй эмийн жагсаалт” гэх)-д багтсан эмийг жор бичих эрх бүхий эмчийн бичсэн жорыг үндэслэн даатгуулагчид хөнгөлөлттэй олгох, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг худалдан авагч нь “чанарын болон төлбөр”-ийн хяналт, гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулна.

1.3. Талууд үйл ажиллагаанд Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль холбогдох бусад хууль, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталсан журам заавар болон энэхүү гэрээг дагаж мөрдөнө.

1.4. Холбогдох харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд, эсхүл талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулж болно.

1.5. Талуудын харилцах сувгийг тодорхойлсон хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг (цаашид “гэрээний баримт бичиг” гэх) болно.

1.6. Талууд гэрээтэй холбоотой асуудлаар зөвхөн албан ёсны хүрээнд харилцах ба үүнд энэхүү гэрээний хавсралтад заасан харилцах сувгаар цаасан ба цахим хэлбэрээр илгээсэн албан бичиг, төлбөрийн нэхэмжлэл, түүнчлэн тэмдэглэлээр баталгаажсан уулзалт хамаарна.

### **ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОРИГЛОХ ЗҮЙЛ**

2.1. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг худалдан авагч дараах эрх эдэлнэ:

2.1.1. иргэн, даатгуулагчид үзүүлсэн тусlamж, үйлчилгээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.8.6, 14.8.7-т заасан холбогдох журмын дагуу чанарын болон төлбөрийн хяналт хийх;

2.1.2. эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчийн иргэн, даатгуулагчид үзүүлэх тусlamж, үйлчилгээний урьдчилгаа болгож, өмнөх сарын гүйцэтгэлийн санхүүжилтийн 50 хүртэлх хувиар тооцон урьдчилгаа санхүүжилтийг сар бүрийн 11-ний дотор эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчид олгох;

2.1.3. эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчид олгосон тусlamж, үйлчилгээний зардлын урьдчилгаа төлбөр нь шаардлага хангасан нэхэмжлэлийн төлбөрийн дүнгээс давсан тохиолдолд зөрүүг дараагийн саруудын урьдчилгаа төлбөрөөс суутгах;

2.1.4. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн нэхэмжлэлийг цахим хяналтаар хянах явцад нэхэмжлэлийн шалгуур хангахгүй тохиолдлын давтамжийг харгалzan газар дээр очиж хяналт шалгалтыг хийх;

2.1.5. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс холбогдох хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт, мэдээллийг шаардаж гаргуулах;

1117149846  
ТУЗ0845 А 5244706

2.1.6. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.8.6, 14.8.7-т заасан холбогдох журмын шалгуурыг хангаагүй тусламж, үйлчилгээний тохиолдлын төлбөрийн санхүүжүүлэхгүй байх ;

2.1.7. дараах тохиолдолд холбогдох баримт, нотолгоог үндэслэн тусламж үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийг хянах болон санхүүжүүлэхээс татгалзах:

2.1.7.1. гэрээний 3.3.1, 3.3.2, 3.3.3, 3.3.4, 3.3.5-т заасан шалтгаанаар гэрээг түдгэлзүүлэн шалгахад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн буруутай нь нотлогдсон тохиолдолд энэ хугацаанд харгалзах тусламж, үйлчилгээний нэхэмжлэл;

2.1.7.2. гэрээний 2.4.4-т заасан хугацаанаас хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоцроосон нэхэмжлэл;

2.1.7.3. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч нь тусгай зөвшөөрөлд заасан хаяг, байршилд өөр хаяг байршилд үйлчилгээ үзүүлсэн тохиолдлын нэхэмжлэл;

2.1.7.4. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийн хугацаа нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр сунгагдахдаа уг хугацаа дуусгавар болсон өдрөөс нөхөж сунгагдсан тохиолдолд дээрх хугацаан дахь тусламж, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэл;

2.1.7.5. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэхэд баримтлах эмийн үнийн дээд хязгаарыг хэтрүүлсэн, даатгуулагчаас илүү төлбөр авсан, даатгуулагчид нэмүү өртгийн албан татварын урамшууллын систем (НӨАТУС)-ийн баримтын хувийг олгоогүй нь нотлогдсон тохиолдлын нэхэмжлэл;

2.1.7.6. даатгуулагчийн өвчний онош, нас, хүйсэнд тохироогүй эмээр үйлчилсэн, тухайн эмийн хэрэглэх арга, гаж нөлөө, үл нийцтийг үл харгалзан, эмийн уух хугацаа дуусаагүй байхад эмийг давхардуулан олгосон нь нотлогдсон тохиолдлын нэхэмжлэл;

2.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч дараах үүрэг хүлээнэ:

2.2.1. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн нэхэмжлэлийг хянаж, хяналтын үр дүнд суурилан шаардлага хангасан нэхэмжлэлийн төлбөрийн хэмжээг тогтоох;

2.2.2. гэрээний 2.2.1-т заасан тооцооны үр дүнд үндэслэн нэхэмжлэлийн хяналт дууссанаас хойш холбогдох журамд заасан хугацаанд багтаан тусламж, үйлчилгээний төлбөрийн урьдчилгаа болон гүйцэтгэлийн зөрүүг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх;

2.2.3. а) төлбөрийн нэхэмжлэлийн хяналтын тайлан, б) эрүүл мэндийн байгууллага дээр хийх хяналт, гэрээний хэрэгжилтийг хянасан тухай дүгнэлт, с)

эмнэлзүйн аудит хийсэн шинжээчийн дүгнэлт тус бүрийг хяналт дууссанаас хойш ажлын 5 хоногт тус багтаан эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэх;

2.2.4. нэхэмжлэлийн хяналтын талаар болон албан тушаалтны ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн талаар гаргасан гомдлыг гомдол хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан хянан үзэж, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчид хариу хүргүүлэх;

2.2.5. тусlamж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын үр дүнд хагас, бүтэн жилээр дүн шинжилгээ хийж, тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчид зөвлөмж өгөх;

2.2.6. эрүүл мэндийн даатгалын цахим мэдээллийн сан, тусlamж, үйлчилгээний чанар, зардлын төлбөрийн хяналттай холбоотой журам, шалгуур, аргачлал, удирдамж, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээллийг эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчид тухай бүр хүргүүлэх;

2.2.7. эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчид эрүүл мэндийн даатгалын мэдээллийн санд хандах техникийн боломжийг олгох, системийн хөгжүүлэлт, хэвийн ажиллагааг хангах, мэдээлэл дамжуулах загварыг гаргах;

### 2.3. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгч дараах эрх эдэлнэ:

2.3.1. шаардлага хангасан нэхэмжлэлийн төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжлэх;

2.3.2. даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээний зардалд зориулж эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг худалдан авагчаас урьдчилгаа төлбөр нэхэмжлэх;

2.3.3. хяналтын тайлан, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд тайлан, дүгнэлт хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан холбогдох тайлбар, гомдол, саналаа тусlamж, үйлчилгээ худалдан авагчид хүргүүлэх;

2.3.4. эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг худалдан авагчаас ирүүлсэн энэхүү гэрээний 2.2.4-д заасан нэхэмжлэлийн хяналтын гомдлын хариу тайлбарыг үл зөвшөөрсөн тохиолдолд хуулийн хэрэг, маргаан үүсгэх;

2.3.5. эрүүл мэндийн даатгалын байгууллагын цахим мэдээллийн сангийн зөвшөөрөгдсөн хэсэгт нэвтрэх, холбогдох мэдээллийг шаардах;

### 2.4. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгч дараах үүрэг хүлээнэ:

2.4.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, "Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS 5260:2015 стандартын шаардлагыг мөрдөн, хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг баримтлан, даатгуулагчийн эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, эмчилгээ, үйлчилгээний удирдамж, стандартад заасан, Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, бүртгэлийн хугацаа нь хүчин төгөлдөр бөгөөд зориулалтын газар, хадгалалт, хамгаалалтын зөв горимд хадгалсан чанарын баталгаатай, хэрэглэх хугацаа нь хүчин төгөлдөр, эмийн сав, баглаа, боодол, хаяглалт, тэмдэглэгээ нь бүрэн эмээр даатгуулагчдад эмийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх;



2.4.2. хөнгөлөлттэй эмийн жагсаалтад багтсан эмийг "Цахим жорын систем"-ийн дагуу ширхгээр олгох тохиолдолд тус эмийг найдвартай сав, баглаанд боон, эмийн хаяглалт, тэмдэглэгээг бүрэн хийж даатгуулагчид олгох;

2.4.3. хөнгөлөлттэй эмийн жагсаалтад багтсан эмийг хүртээмжтэй байх хангалтыг хийх;

2.4.4. тусlamж, үйлчилгээний зардлын нэхэмжлэлийн мэдээллийг цахим системээр, албан бичгийг гэрээний баримт бичигт заасан холбогдох хаягаар эсхүл орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсийн албан ёсны цахим хаягаар сар бүрийн 5-ны дотор хүргүүлэх;

2.4.5. хяналт шалгалт хийхэд шаардагдах баримт, нотолгоо, мэдээллийг тусlamж, үйлчилгээ худалдан авагчид саадгүй гаргаж өгөх, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг худалдан авагчид хяналт шалгалт хийх нөхцөлийг бүрдүүлэх;

2.4.6. гэрээний 2.4.4, 2.4.5-д заасны дагуу гаргаж өгсөн мэдээлэл болон иргэн, даатгуулагчийн талаарх цахимаар илгээсэн мэдээллийн үнэн, зөв байдлыг бүрэн хариуцах;

2.4.7. төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн цаглабартай холбогдуулан тухайн төсвийн жилийн 6, 12 дугаар саруудад үзүүлсэн тусlamж, үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн сарын 10-ны өдрөөр тасалбар болгон хуанлийн 2 хоногт багтаан ирүүлж, 11-ний өдрөөс тухайн сар дуусталх хугацаанд үзүүлсэн тусlamж, үйлчилгээний гүйцэтгэлийг дараа сарын нэхэмжлэлтэй хамтатган хүргүүлэх;

2.4.8. эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг худалдан авагчаас тогтоосон шаардлагад нийцүүлж цахим системээр мэдээлэл солилцох техникийн боломж бүрдүүлэх;

2.4.9. эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг худалдан авагчийн баталсан загварын дагуу цахимаар мэдээллийг ирүүлэх;

2.4.10. эмийн үнийн төлбөр тооцоог бүртгэлийн машинаар /кассын машин, түүний салшгүй хэсэг болсон ПОС терминал буюу түүнтэй адилтгах програм хангамж бүхий тоног төхөөрөмж/ гүйцэтгэж, төлбөрийн баримтыг хоёр хувь хэвлэн, НӨАТУС бүхий баримтын нэг хувийг даатгуулагчид заавал өгөх;

2.4.11. эмийн сангийн хаяг, байршилд болон бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдолд 10 ба түүнээс дээш хоногийн өмнө эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг худалдан авагч байгууллагад урьдчилан албан бичгээр мэдэгдэх;

2.4.12. хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг даатгуулагч, иргэдэд зориулан ил тод, харагдахуйц газар байршуулах ба даатгуулагчийг эмийн талаарх үнэн зөв мэдээллээр хангаж, олгосон эмийг хэрэглэх заavarчилгааг өгөхөөс гадна эмийн сонголт болон эм худалдан авалттай холбоотой мэдээллийг харах зориулалт бүхий дэлгэцийг кассан дээр байршуулах;

2.4.13. даатгуулагчдад үзүүлсэн эмийн үнийн хөнгөлөлтийн тусlamж, үйлчилгээний зардлын гүйцэтгэлийн тооцоог тусlamж, үйлчилгээ худалдан авагч байгууллагатай хагас, бүтэн жилээр хийх;

2.5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно. Үүнд:

2.5.1. эм барих эрх, зөвшөөрөлгүй этгээдийг эм найруулах, бэлтгэх, шалгах, олгох үйл ажиллагаанд оролцуулахгүй байх;

2.5.2. зах зээлд гаргах зөвшөөрөлгүй, улсын бүртгэлд бүртгүүлээгүй, хуурамч, чанарын баталгаагүй, хугацаа дууссан эмээр үйлчлэх;

2.5.3. ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор эмчээр эм борлуулах, үр дүнгээр урамшуулах, түүнтэй адилтгах үйл ажиллагаанд татан оролцуулах, үгсэн хуйвалдах;

2.5.4. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг зөрчин зар сурталчилгаа явуулах, тулган шаардах, буруу ташаа мэдээлэл өгөх, үйлчлүүлэгчийн сонгох боломжийг хязгаарлах;

2.5.5. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч байгууллагад эмийн сангийн стандарт, санхүүгийн болон хүний нөөц, бусад асуудлаар худал мэдээлэл ирүүлэх, даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх;

2.5.6. эрүүл мэндийн даатгалын байцаагч болон Төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий хуулийн этгээд, албан тушаалтны тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, төөрөгдүүлэх, хяналт, шалгалтанд холбогдолтой баримт бичгийг засварлах, гэмтээх, устгах, зайлсхийх, хуурамч баримт бичиг гаргаж өгөх;

## **ГУРАВ. ГЭРЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛОХ**

3.1. Дараах тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна:

3.1.1 эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн хаяг, байршилд болон бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдолд;

3.1.2 хуульд заасан бусад үндэслэл;

3.2. Гэрээнд өөрчлөлт оруулах саналыг бичгээр гаргах бөгөөд өөрчлөлтийг талууд хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурснаар гэрээний өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

3.3. Дараах тохиолдолд гэрээг түдгэлзүүлнэ.

3.3.1. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд гэрээг бүхэлд нь;

3.3.2. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэлийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч шалгах явцад алдаа, зөрчил илэрч, дахин нягтлан шалгах шаардлага гарсан тохиолдолд гэрээг бүхэлд нь;

3.3.3. эрх бүхий этгээдээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хэсэгчлэн болон бүхэлд нь зогсоо шийдвэр гаргасан бол гэрээг бүхэлд нь эсхүл гэрээний баримт бичгийн холбогдох хэсгийг;

3.3.4. эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгч гэрээг бүхэлд нь эсхүл гэрээний холбогдох баримт бичгийн тодорхой хэсгийг түр түдгэлзүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд;

3.3.5. эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээтэй холбоотой асуудлаар хууль, хяналтын байгууллагаар шалгагдаж байгаа тохиолдолд тухайн эмийн сангийн асуудал шийдвэрлэгдэх хүртэлх хугацаанд;

3.4. Дараах тохиолдолд нотлох баримтад үндэслэн гэрээг бүхэлд нь эсхүл гэрээний баримт бичгийн холбогдох хэсгийг түдгэлзүүлснийг цуцлах эсэхийг шийдвэрлэнэ:

3.4.1. эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчээс энэхүү гэрээний 3.3.1, 3.3.4-т заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн шалтгааныг шийдвэрлэсэн тухай мэдэгдлийг эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг худалдан авагчид ирүүлснээс хойш ажлын 5 хоногийн дотор;

3.4.2 энэхүү гэрээний 3.3.2, 3.3.3, 3.3.5-т заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн шалтгааныг шийдвэрлэсэн тухай мэдэгдлийг эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг худалдан авагчид ирүүлснээс хойш ажлын 10 хоногийн дотор;

3.5. Дараах тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцална:

3.5.1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан хөнгөлөлттэй эмийн жагсаалтын үнийн дээд хэмжээг мөрдөөгүй, иргэн даатгуулагчаас уг жагсаалтад баталсан эмэнд иргэний төлөх төлбөрийг даатгуулагчаас нэмэгдүүлж авсан;

3.5.2. явцын хяналт шалгалтаар гурваас дээш удаа зөрчилтэй нь илэрсэн;

3.5.3. эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчийн сар бурийн нэхэмжлэлд эзлэх зөрчилтэй нэхэмжлэлийн хуримтлагдсан хувь хэмжээ нь 10 хувь болсон тохиолдолд;

3.5.4. хууль, хяналтын байгууллагаас мэргэжлийн алдаа дутагдал гаргасан, хуурамч баримт бичиг бүрдүүлснийг нь тогтоосон;

3.5.5. эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгч нь тусlamж, үйлчилгээ худалдан авагчийн хяналт шалгалт явуулах үйл ажиллагаанд саад учруулсан, хяналт шалгалт хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, зайлсхийсэн, хяналт шалгалтад нөлөөлөхийг оролдсон, хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийг арилгаагүй, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд;

3.5.6. гэрээний 2.5-т заасан эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хориглох зүйлсийг зэрчсөн нь нотлогдсон тохиолдолд;

3.5.7. эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгч гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах хүсэлт гаргасан тохиолдолд;

3.6. Тусlamж, үйлчилгээ худалдан авагч нь гэрээний 3.5.1-3.5.6-т заасан үндэслэлээр гэрээг шууд, гэрээний 3.5.7-т заасан үндэслэлээр гэрээг цуцлах тохиолдолд хүсэлтийг үндэслэн гэрээг цуцалж, гэрээ цуцалсан тухай мэдэгдлийг

эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчид цуцлах шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор албан бичгээр хүргүүлнэ.

## ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА



4.1. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг худалдан авагч гэрээний үүргийг биелүүлээгүй нь тогтоогдвол дараах хариуцлага хүлээнэ:

4.1.1. энэхүү гэрээний 2.1.2, 2.2.2-т заасан төлбөрийг хугацаанаас хожимдуулж төлсөн тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн мөнгөн дүнгээс 0.05 хувиар тооцож, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчид алданги төлнэ.

4.1.2. эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээний нууцлалыг хангаагүй бол холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээнэ.

4.2. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгч энэхүү гэрээний 2.4.4-т заасан үүргээ хүндэтгэн үзэх шалтгааны улмаас биелүүлээгүй тохиолдолд хоцроосон хоног тутамд холбогдох тусlamж, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийн дүнгийн 0.5 хувиар тооцож суутган, хариуцлага хүлээлгэнэ.

## ТАВ. ГЭРЭЭГ ДҮГНЭХ

5.1. Энэхүү гэрээг эрх бүхий этгээдээс баталсан гэрээ дүгнэх аргачлал, журмын дагуу дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор дүгнэнэ.

5.2. Гэрээний хэрэгжилтийн явц, үр дүнгийн үнэлгээний тайланг эрүүл мэндийн даатгалын байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлнэ.

## ЗУРГАА. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

6.1. Энэхүү гэрээтэй холбоотой талуудын хооронд үүссэн аливаа маргааныг дараах арга замаар шийдвэрлэнэ:

6.1.1. нэхэмжлэл, чанар, төлбөрийн хяналттай холбогдох маргааныг холбогдох журмын дагуу;

6.1.2. хэрэв аль нэг тал маргааныг хэлэлцээ хийж шийдвэрлэхээр бичгээр хүсэлт тавьснаас хойш ажлын 10 хоногт, эсхүл энэхүү гэрээний 6.1.1-т заасны дагуу талууд нэгдсэн шийдвэрт хүрч чадаагүй бол Захиргааны хэргийн шүүхээр;

6.2. Талууд энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргаан шийдвэрлэхэд зөвхөн албан бичгээр харилцсан харилцааг баримт, нотолгоо болгоно.

6.3. Гэрээ, гэрээний баримт бичигтэй холбогдох аливаа маргаан болон гэрээнд өөрчлөлт оруулах, хэлэлцээр хийх зэрэг гэрээний аливаа харилцаанд талууд өөрсдөө төлөөлөн оролцох бөгөөд уг харилцаанд гуравдагч талыг оролцуулахгүй.



## ДОЛОО. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

7.1. Энэхүү гэрээ болон гэрээний баримт бичиг нь талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

7.2. Гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭГ ХУДАЛДАН АВАГЧИЙГ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:  
(Албан тушаал, нэр)  
(Гарын үсэг) \_\_\_\_\_

ТАМГА

(Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг (Тусlamж, эрүүл мэндийн tuslamж,  
худалдан авагчийн хаяг) үйлчилгээ үзүүлэгчийн хаяг)  
(Утас, факсын дугаар) (Утас, факсын дугаар)  
(Харилцагч банкны нэр, дансны дугаар)

..... дугаар гэрээний хавсралт



ТАЛУУДЫН ХАРИЛЦАХ СУВАГ

Харилцах асуудал	Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг худалдан авагчийн:	Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгчийн:
1. Цахим хаяг:		
Тусlamж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, өртөг зардал, төлбөрийн аргын асуудлаар		
Сонгон шалгаруулалт, гэрээлэлт, гэрээний үр дүнгийн хяналтын асуудлаар		
Тусlamж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын асуудлаар		
Санхүүжилт, төлбөр тооцоотой холбоотой асуудлаар		
Програм хангамжийн асуудлаар		
Бусад нийтлэг асуудлаар		
2.Шуудангийн хаяг:		